



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2023/124/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2023 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnogovi@audit.gov.mn

2023.02.09 № 29

танай _____ -ны № _____ -т

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ШҮРЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр 6 дугаар ангийн сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн урлагийн заалны зураг төсвийг хүлээн авч бараа материал дансны үлдэгдэл 28.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020039

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)		
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	56.8	546.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,019.4	6,946.8
Нийт хөрөнгийн дүн	7,076.2	7,493.3
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,076.2	7,493.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,076.2	7,493.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,558.7	3,089.9
Үйл ажиллагааны зардлын дүн	1,870.5	2,641.7
Үйл ажиллагааны үр дүн	(311.8)	448.2
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(31.1)
Үйл ажиллагааны нийт үр дүн	(311.8)	417.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,388.0	7,076.2
Тайлант оны үр дүн	(311.8)	417.1
Эцсийн үлдэгдэл	7,076.2	7,493.3
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,558.7	2,821.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,547.0	2,335.9
Үйл ажиллагааны ЦМГ	11.7	485.8
Хөрөнгө оруулалтын ЦМГ	11.7	66.6
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	419.2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	419.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,688.6	2,273.6
Урсгал зардал	2,688.6	2,273.6
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,688.6	2,692.8
Улсын төсвөөс санхүүжих	2,502.5	2,502.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	183.9	176.7
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2.2	13.6
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		419.2

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 325.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 325.7 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа.

Аудитаар Саммит компьютер ХХК-иас 39.5 сая төгрөгийг тоног төхөөрөмжийн үнэ гэж олгосон боловч тоног төхөөрөмж нь ирээгүй байхад авлагаар бүртгээгүй, ФючерсСкүүл Монголий ХХК-с худалдан авсан Шалгалтын хариу засах 7.0 сая төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг шууд зардалд бүртгэсэн, Бат баян уул ХХК нь тайлант онд хүүхдийн өдрийн хоолыг нийлүүлж байгаа бөгөөд хүнсний материал хэсэгт орлогод бүртгэсэнтэй холбоотой 279.2 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитаар нийт 21.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 6.6 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 3 заалт бүхий зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.2 Албан шаардлага

3.2.1 Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сургуулийн интернэтийн төлбөрийг Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-аас төлсөн байхад 2022 онд интернэтийн төлбөрт 6.6 сая төгрөгийг төлж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-тай гэрээ байгуулан интернэтийн үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжтэй холбогдон сургуулийн интернэтийн тоног төхөөрөмжийг хүлээн авч үйл ажиллагаандаа тус интернэтийг хэрэглэн төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн ажиллаж төсвөөс мөнгөн хөрөнгө давхардуулан гаргаж байгааг таслан зогсоох.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагад бараа материалын шинж чанартай 34 нэр төрлийн зүйлийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 17-ын 13-д Үндсэн хөрөнгө гэж “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө”, 17-д “эд анги ба үйлчилгээний тоног төхөөрөмжийг ихэнх тохиолдолд бараа материал гэж ангилах ба ашигласан хэмжээгээр ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй бараа материалыг залруулан хангамжийн материал дансанд тусган ажиллах

2. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хууль	1	15,200.0			1	15,200.0		
Дүн	1	15,200.0	0	0	1	15,200.0	0	
Нийт дүн	1	15,200.0			1	15,200.0		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			